

**БАТЛАВ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**Ү.ТӨМӨРХУЯГ**

Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 23

**“ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ЖУРНАЛ, МАЯГТУУД НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалт/ гэрээний  
дугаар: ДЦС4/2020-115

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) ТООЗ-д заасан шаардлагууд
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь нэг багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар</li> <li>• Туршлагын мэдээлэл болон үйл ажиллагааны түүх ирүүлнэ.</li> </ul>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>“ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө мэргэжилтэн Ж.АЙдос Утас: 70181309</i></p> <p>Огноо: <i>2020 оны 09-р сарын 29 ний өдөр</i> Цаг: <i>10 цаг 00 минут</i></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер нээх хаяг, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>“ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө</i></p> <p>Огноо: <i>2020 оны 09 -р сарын 29 -ний өдөр</i> Цаг: <i>10 цаг 30 минут</i></p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>ДЦС4/2020-115 дугаартай “Тусгай зориулалтын журнал, маягтууд”</i> нийлүүлэх нэг багцаас бүрдэнэ.</p>

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА ТОДОРХОЙЛОЛТ

## Тусгай зориулалтын журнал, маягтууд ХХА

Дд	Барааны код	Барааны нэр	Тоо хэмжээ	Х.Нэгж
1	1801013034	Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэг	30	ширхэг
2	1801013701	Агуулахын бүртгэл	50	ширхэг
3	1801010202	Албан бланк А4	6000	ширхэг
4	1801010203	Албан бланк А5	5000	ширхэг
5	1801011010	Албан хэргийн заавар ном	10	ширхэг
6	1801011051	Аюулгүй ажиллагааны холбогдолтой гарын авлага	300	ширхэг
7	1801012016	Аюулыг мэдээлэх хуудас /дэвтэр/	128	ширхэг
8	1801011130	Гарын авлага - Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал	300	ширхэг
9	1801012019	Генераторын ба трансформаторын тоолуурын заалтын маягт	1000	ширхэг
10	1801012010	Горимын хоногийн үзүүлэлт	370	ширхэг
11	1801013023	Гэмтлийн журнал	140	ширхэг
12	1801010409	Даргын тушаал А4	5000	ширхэг
13	1801012012	Дотоод циклийн ус бэлтгэлийн хоногийн үзүүлэлт №1	375	ширхэг
14	1801012041	Дотоод циклийн ус бэлтгэлийн цах деионизацийн хоногийн үзүүлэлт №1	37	ширхэг
15	1801010401	Дугтуй А4	1000	ширхэг
16	1801010402	Дугтуй А5	470	ширхэг
17	1801010403	Дугтуй А6	350	ширхэг
18	1801012004	ДЦС зуухны усны хоногийн үзүүлэлт	2000	ширхэг
19	1801016003	ДЦС-4 логотой тэмдэг	10	ширхэг

20	1801013024	Жижүүр хүлээлцэх дэвтэр	5	ширхэг
21	1801013007	Засварчдын зааварчилгааны журнал	82	ширхэг
22	1801012002	Зуухны ажиллагааны хоногийн үзүүлэлт	5000	ширхэг
23	1801013014	Илчлэг тодорхойлох дэвтэр	40	ширхэг
24	1801014843	Журнал - Ирсэн бичиг бүртгэх	15	ширхэг
25	1801013017	Ирсэн ачааны бүртгэлийн журнал	4	ширхэг
26	1801013031	Краны захиалгын журнал	12	ширхэг
27	1801013033	Краны өдөр тутмын үзлэгийн журнал	34	ширхэг
28	1801013032	Краны урьдчилан сэргийлэх үзлэгийн журнал	4	ширхэг
29	1801012003	Мазут аж ахуйн хоногийн үзүүлэлт	200	ширхэг
30	1801013006	Мастерын дэвтэр	34	ширхэг
31	1801013703	Материал зарцуулалтын журнал	2	ширхэг
32	1801013008	Машин механизмын журнал /65-р маягт/	30	ширхэг
33	1801012028	Метрикс карт	17200	ширхэг
34	1801013021	Наряд шийдвэрийн журнал	112	ширхэг
35	1801012022	Нарядын хуудас	26000	ширхэг
36	1801013105	НББ-ын төрөл бүрийн дэвтэр, журналууд	26	ширхэг
37	1801012011	НДГА ажиллагааны хоногийн үзүүлэлт	375	ширхэг
38	1801013019	Нүүрсний сорьц шинжилгээний журнал	4	ширхэг
39	1801013016	Нүүрсний техникийн хураангуй шинжилгээний журнал	50	ширхэг
40	1801012408	Нэхэмжлэх	10	ширхэг
41	1801012033	ПЭН-ийн ажиллагааны хоногийн үзүүлэлт	600	ширхэг
42	1801013010	Реагантын журнал	30	ширхэг
43	1801012412	Санхүүгийн маягууд А5	500	ширхэг

44	1801012040	Станцын дотоод циклийн ус бэлтгэлийн насосны хоногийн үзүүлэлт /хими цех/	350	ширхэг
45	1801012039	Станцын дотоод циклийн ус бэлтгэлийн хоногийн үзүүлэлт /хими цех/	370	ширхэг
46	1801012005	Сүлжээний ажиллагааны хоногийн үзүүлэлт	500	ширхэг
47	1801011128	Сэлбэг материалын бүртгэл журнал	5	ширхэг
48	1801013009	Техникийн хичээлийн журнал	31	ширхэг
49	1801012013	Тоноглолын дэвтэр	400	ширхэг
50	1801012415	Тооллогын шошго	2000	ширхэг
51	1801010410	ТУЗ-ын тогтоолын хуудас	600	ширхэг
52	1801012034	Турбогенераторын ажиллагааны хоногийн үзүүлэлт	3300	ширхэг
53	1801013026	Тушаал тогтоол, захирамжын журнал	4	ширхэг
54	1801012017	Уур болон уур дахин боловсруулах ажиллагааны хоногийн үзүүлэлт	500	ширхэг
55	1801013029	Уусмал бэлтгэлийн журнал	12	ширхэг
56	1801012101	Үйлдвэрлэлийн зориулалтын маягтууд А5	400	ширхэг
57	1801013101	Үйлдвэрлэлийн зориулалтын төрөл бүрийн журналууд	57	ширхэг
58	1801013028	ХАБЭАЗ-ын журнал	30	ширхэг
59	1801013020	ХАБЭМС-ийн зааварчилгааны журнал	700	ширхэг
60	1801012009	Хими ус цэвэрлэгээний хоногийн үзүүлэлт /ДШС/	350	ширхэг
61	1801012008	Химийн түүхий усны цэвэрлэгээний хоногийн үзүүлэлт /ЭО/ №1	375	ширхэг

62	1801012007	Химийн түүхий усны цэвэрлэгээний хоногийн үзүүлэлт /ЭО/ №2	300	ширхэг
63	1801013012	Хөдөлмөр хамгааллын шатны үзлэгийн журнал	82	ширхэг
64	1801010412	Хувьцаа эзэмшигчдийн тогтоолын хуудас	60	ширхэг
65	1801014840	Хэвлэмэл хуудас - Ажилтны анкет	800	ширхэг
66	1801014842	Хэвлэмэл хуудас - ТУЗ-ийн хурлын тэмдэглэл	100	ширхэг
67	1801014841	Хэвлэмэл хуудас - Эрүүл мэндийн үзлэг	600	ширхэг
68	1801013002	Шалгалтын журнал /станц/	47	ширхэг
69	1801013003	Шалгалтын журнал /цех/	41	ширхэг
70	1801013005	Шинжилгээний журнал	57	ширхэг
71	1801013004	Шуурхай ажиллагааны журнал	1200	ширхэг
72	1801013030	Шүүлтүүр сэргээлтийн журнал	5	ширхэг
73	1801013027	Явуулсан бичиг бүртгэх журнал	15	ширхэг
74	1802090380	Автомат нуруулдагч машин Т80	2	ширхэг
75	1801011012	Монгол менежер дэвтэр	7	ширхэг

**Жич: Барааг нэг доор авахгүй ба захиалгын дагуу 7 хоногийн дотор нийлүүлнэ.**

1. БАРААН ДЭЭР НИЙТ ҮНИЙН САНАЛ ИРҮҮЛНЭ.
2. Баглаа, боодол: Зориулалтын дагуу савалж гадуур нь хайрцагласан байна.
3. Бараа хүргэх газар: “ДЦС-4” -ийн төв агуулахад нийлүүлэгч өөрийн зориулалтын машинаар хүргэнэ
4. Үнийн дүнд НӨАТ ТӨЛӨГЧ БОЛ шингээсэн байх.
5. Бараа нийлүүлэлтийн хуваарь ирүүлэх бараа тус бүр дээр

Дөрөв. “Тусгай хэвлэлийн бараа” бараа нийлүүлэх үнийн саналын маягт

[огноо]

**“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.ТӨМӨРХУЯГ** танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:





## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа <b>[нэг]</b> жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. Зах зээлийн үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд өрсөлдөгч компаниудын үнийн харьцуулалтыг үндэс болгоно  |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30-аас 90 хоногийн дотор хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах        | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

Захиалагч

Нийлүүлэгч

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Захиалагч чанарын баталгааны бичиг, худалдан борлуулах зөвшөөрлийг шалгана.<br>1.2. Нийлүүлэх барааны сав, баглаа боодол нь баталгаажсан эсэхийг шалгана   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;<br>2) барааны гарал үүслийн гэрчилгээ.<br>1 жилийн хугацаанд саадгүй нийлүүлнэ.  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн болон ашиглалтын явцад баглаа боодол гэмтсэн, чанар өнгө үзэмж алдагдсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Нийлүүлэгчид <b>Урьдчилгаа төлбөр</b> олгохгүй бөгөөд гэрээгээр нийлүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэх зарлагын баримт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч бараа хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор төлбөрийг хийнэ.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны үнийн дүнд хэтэрсэн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хоног дутамд <b>0,1%-ийн алданги ноогдуулна.</b><br>Захиалагч нийлүүлэгчийн төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хэтэрсэн хоног дутамд <b>0,1%-ийн алданги ноогдуулна.</b><br>Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн <b>30%-аас</b> хэтрэхгүй байна. |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ДЦС-4 ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

**Ү.ТӨМӨРХУЯГ**

ЗАХИРАЛ .....

ТУСГАЙ ХЭВЛЭЛИЙН БАРАА НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас **“ДЦС-4” ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч **Н2019/114** дугаартай .....-г (цаашид “бараа” гэх) ..... (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч 1 жилийн хугацаатай гэрээг байгуулав.. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь барааг захиалагчийн захиалгын дагуу нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - Үнийн санал;
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Гэрээний ерөнхий нөхцөл;Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН**

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

БҮЭД ЗАХИРАЛ:

А.БЯМБАДОРЖ

“.....” ХХК-ИЙН

ЭЗСА-Н ДАРГА:

Д.ТӨМӨРТОГОО

МЕНЕЖЕР

ХААХ-ИЙН ДАРГА:

О.ГАНТӨМӨР

ХААХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:

С.ЧИНБАТ

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

А.АРИУНБОЛД

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

С.ДОНИД